

Бодлого судлалын ерөнхий ойлголт: Монгол дахь бодлогын судалгааны үндэс

General concepts of policy study: Foundations of policy study in Mongolia

Лувсанбаярын Уянга¹

Магистр

Шинжлэх Ухааны Академийн

Философийн хүрээлэн

Бодлого судлал, улс төрийн эдийн

засгийн ухааны салбар

uyangal@mas.ac.mn

Uyanga Luvsanbayar

Master of Arts

Department of Policy Studies & Political

Economy,

Institute of Philosophy,

Mongolian Academy of Sciences

uyangal@mas.ac.mn

Хураангуй:

Бодлого судлалын гол судлагдахуун нь төрийн бодлого хийгээд түүнийг хэрэгжүүлэх үйл явц юм. Төрийн бодлогын тухай олон тодорхойлолт байдгаас Томас Дэй, Виллиам Женкинс, Жеймс Андерсон нарийн тодорхойлолтуудыг нэгтгэн “Төрийн бодлого гэдэг нь төрийн байгууллага, албан тушаалтнуудын хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд нийгэмд тулгамдсан асуудлыг хэсэгчилсэн болон цогц байдлаар шийдвэрлэх үйл ажиллагааны чиглэл юм” хэмээн тодорхойлж болно.

Монгол Улсад бодлогын судалгаа нь төрийн бодлого үйл ажиллагаанд заавар, зөвлөмж өгөх үүрэг бүхий үүссэн ч өнөө үед бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлтээрээ хамгийн хүчтэй улс орон л байгаа бүх боломж бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж чадаж байна. Тиймээс цаг үе, нийгмийн өөрчлөлтийг урьдчилан тооцоолох чадвартай, үнэн, зөв, бодитой мэдээллийн эх сурвалж бүхий Бодлогын судалгааны

Abstract:

The main subject of the Policy study is state policy and its execution method. As there are many definitions and interpretations regarding state policies, respective to Thomas Dye, William Jenkins, and James Anderson's interpretations can be summarized as “State policy shall be operative agenda of the government and its agents to partially or wholly address the necessities of the society”.

Initially, a Policy study was established in Mongolia with the aim to offer recommendations and suggestions on state policies and government operations, but these days the ones with substantial capability in policy development and its implementation are the ones who are of using it to the fullest extension.

Therefore, it is imperative to focus on the establishment or development of a policy study institution that has a reliable and accurate source of information and is capable of anticipating changes in society.

¹ © Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

институцийн хөгжилд нэн түрүүнд анхаарах нь чухал юм.

Түлхүүр үгс: *улс төрийн бодлого, бодлогын ухаан, бодлогын судалгаа, бодлогын шинжилгээ*

Keywords: *political policy, policy science, policy study, political analysis, public policy analysis*

I. Оршил

“Бодлого судлалын ерөнхий ойлголт: монгол дахь бодлогын судалгааны үндэс” сэдэвт уг өгүүлэл нь бодлого судлалын энгийн ойлголтууд хийгээд монголд хэрхэн үүсэж, төлөвшиж буй талаарх тойм өгүүлэл юм. Ингэхдээ тус өгүүллээрээ дамжуулан бодлого судлалын орчин үеийн хэрэгцээ шаардлагыг илүү тодотгохыг зорилоо.

Өгүүллийн эхэнд бодлогын ухаан үүсэн бий болох хэрэгцээ шаардлага, үүсэл хөгжлийн тодорхой үе шатуудын талаар болон бодлогын ухаан нь олон шинжлэх ухааны уулзварт үүсэж судалгаа, шинжилгээний хувьд ч олон шинжлэх ухааны мэдлэг, туршлагыг шаарддагаараа бусад шинжлэх ухаанаас ялгарах онцлогтойг товчхон өгүүллээ. Өгүүллийн хоёр дугаар хэсэгт монголд бодлогын судалгааны үндэс, суурь хэрхэн тавигдаж буй талаар болон дурьдсан болно.

1980-аад оноос хойш Бодлогын шинжлэх ухаан улам нарийсаж төрийн бодлого, бодлогын шинжилгээ хэмээх салбар шинжлэх ухаанууд бий болсон.

Төрийн бодлогыг судлах нь нэгд, шинжлэх ухааны судлагдахуун болох үүднээс, хоёрт, зөв улс төрийн бодлого хэрэгжүүлэх зорилгоор, гуравт, үр нөлөөтэй оролцоог дэмжих зорилгоор, төгсгөлд нь шинжлэх, зөвлөх буюу мэргэжлийн үүднээс судлах шаардлагатай юм. Энэхүү зорилго, зорилтуудын хүрээнд монголд бодлого судлалын шинжлэх ухааныг системтэйгээр хөгжүүлэх шаардлагатай юм.

Төрийн бодлогыг үр ашигтай хэрэгжүүлэхэд тодорхой арга, хэрэгслүүд шаардлагатай. Тэдгээр хэрэгслүүдийн нэг нь ‘Бодлогын шинжилгээ’ юм. Өөрөөр хэлбэл төрийн бодлогыг задлан оншлох явдал юм. Бодлогын зөв шийдвэрт хүрэх үндсэн зорилгын хүрээнд бүхий л тулгамдсан асуудал, зөрчлийг илрүүлэхийн зэрэгцээ бодлогын орчин, эдийн засгийн боломжит байдлын хамт цогцоор нь судлахыг шаардана. Энэ утгаараа бодлогын шинжилгээ нь орчин үеийн улс, төрийн шинжлэх ухааны хамгийн эрэлтэд салбар ухаан юм.

Бодлого судлал нь нэг талаас шинжлэх ухааны өөрийн дотоод хэрэгцээнээс үүдсэн, нөгөө талаасаа практик эрэлтээс үүдсэн дараах үүрэгтэй. Тухайлбал, Шинжлэх ухааны дотоод хэрэгцээнээс үүдсэн үүргийн хүрээнд шинжлэх ухааны мэдлэгийг нэмэгдүүлэх, шинэчлэх, судалгааны шинэ чиглэл, аргагүй боловсруулах зэрэг үүрэгтэй бол практик эрэлтээс үүдсэн үүргийн хүрээнд төрийн бодлого, үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийгмийн аливаа үзэгдэл, үйл явдлыг тайлбарлах, болж болзошгүй асуудал бэрхшээлийг урьдчилан тооцоолох зэрэг үүргүүдийг гүйцэтгэнэ. Тиймээс бодлогын ухаан нь шинжлэх ухаан болоод нийгмийн хэрэгцээ шаардлагын хувьд маш чухал салбар шинжлэх ухаан болохыг энэхүү богино өгүүлэлдээ товчхон өгүүлэхийг хичээлээ.

II. Судалгааны арга зүй

Тус өгүүлэлд баримт материалын шинжилгээний аргыг ашиглав. Ингэхдээ философийн судалгааны индукци, дедукцийн ерөнхий аргуудын хүрээнд зарим хэсэгчилсэн ойлголт, дүгнэлтүүдийг нэгтгэх болон задлан шинжлэх замаар өөрийн өгүүллийн санааг гаргахыг зорьсон болно.

III. Судалгааны үр дүн

Удирдлагын академийн Төрийн удирдлагын тэнхимийн багш Я.Бямбасүрэн, П.Доржсүрэн нарын “Төрийн бодлого” оюутан, судлаачдад зориулсан гарын авлага, доктор, профессор А.Цанжидын англи хэлнээс орчуулсан Жои Юл Ли, Чад Андерсон нарын “Бодлогын шинжилгээ” орчуулгын бүтээл зэрэг нь бодлого судлал, бодлогын шинжилгээний талаарх үндсэн ойлголт, онол, үзэл баримтлалын талаар авч судалсан манай улсад энэ чиглэлээр хийгдсэн анхны бүтээлүүд юм. Мөн шинэ залуу судлаачдад гарын авлага, мэдээлэл болохуйц Н.Наранчимэг “Нийгмийн бодлого”, Я.Бумжаргал “Нийгмийн бодлогын зарим асуудлууд” зэрэг бүтээлүүд хэвлэгдэн гаржээ. Ийнхүү монгол дахь бодлого судлалын салбар ухаан тодорхой түвшинд хүрж, бодлого судлалын үндэс тавигджээ. Үүний бас нэгэн илэрхийлэл нь төрийн бодлого, үйл ажиллагаанд заавар, зөвлөмж болох зорилготой төрийн болоод хувийн хэвшлийн судалгааны олон байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ монголын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн судалгаа, шинжилгээнүүд хийгдэж байгаа нь бодлого судлалын шинжлэх ухааны ач холбогдол болохыг уг өгүүллээр тоймлон хүргэж байна.

Бодлого судлалын ерөнхий ойлголт: Монгол хэлэнд “бодлого” гэдэг нь бодол буюу оюун ухаандаа сэтгэх, эргэцүүлэх[1] гэсэн утгыг илэрхийлэх хэдий ч англи хэлний тайлбар толинд “Policy” буюу “бодлого” гэдэг үгийг “Тодорхой нөхцөлд юу хийх талаар бүлэг хүмүүс, бизнесийн болон төрийн байгууллага, улс төрийн намаас албан ёсоор хүлээн зөвшөөрсөн үзэл санааны цогц, төлөвлөгөө”[2] хэмээн тодорхойлсон байна.

Төрийг хэрхэн удирдах тухай онол, төсөөлөл үүсэн бий болоход эртний олон сэтгэгч хувь нэмэр оруулсан хэдий ч бодлогын шийдвэр гаргах тухай тусгайлан онол, үзэл баримтлалыг анхлан боловсруулсан нь Аристотель юм. Тэрээр төрийн бодлого боловсруулах үйл явцын тухай үндсэн ойлголтыг боловсруулахдаа “тунгаан бодох” (plironesis), “ухамсарт сонголт” (proairesis) гэсэн хоёр ухагдахууныг хэрэглэсэн. Төрийн бодлого шийдвэр нь улс төрийн практик мэдлэгт суурилсан хүний тунгаан бодох үйл ажиллагааны үр дүн байдаг. Ухамсарт сонголт нь төрийн зорилго, шийдвэрт хүрэх оновчтой арга замыг илрүүлэхэд чиглэсэн сэтгэн бодох хийгээд практик үйл ажиллагаа хэмээн үзсэн.

Төрөөс үр нөлөөтэй бодлого, шийдвэр гаргах тухай асуудалд Т.Гоббсын “эрх баригчдад зөвлөгчийн хийгээд зөвлөмжийн үүрэг”, Б.Спиноза, Ж.Руссо нарын “төлөөллийн байгууллага хийгээд санал хураалтын онцлог”, Ж.Боден “нийгмийн хүчин зүйлсийг харгалзах” гэх үзэл санаанууд үнэтэй хувь нэмэр оруулсан байдаг. Гэхдээ улс төрийн ухааны гэгдэх “Бодлогын ухаан” нь дөнгөж ХХ зууны хоёр дугаар хагасаас бие даан салбарлан хөгжиж, төрийн захиргааны онол, практикийн хичээл өрнөдийн их сургуулиудад орж эхэлжээ. Чухам тэр

үед л “бодлогын ухаан” (Policy sciences) гэсэн нэр томъёог Харольд Лассуэлл шинжлэх ухааны эргэлтэнд анх оруулсан байна. Тэрээр “Хэрэв шинжлэх ухаан аливаа нийгэмд бодлого боловсруулж хэрэгжүүлэх үйл явцыг тайлбарлаж, бодлогын асуудлыг шийдвэрлэх рациональ аргыг боловсруулахад хэрэгцээтэй мэдээ, баримтаар хангаж байвал түүнийг бодлогын ухаанд хамааруулж болно”[3] гэжээ.

Бодлогын ухаан үзэл баримтлалын хувьд үүсэн төлөвшихөд дэлхийн хоёр дайны гүнзгий хямрал буюу өөрөөр хэлвэл дайн дэгдэхэд их гүрнүүдийн удирдагчид бодож боловсруулаагүй, үндэслэл муутай шийдвэр гаргаж байсан нь багагүй нөлөөлсөн хэмээн Лассуэлл үзэж байсан. Гэсэн хэдий ч нийтлэг үндэслэлээрээ бол өрнөдийн ардчиллыг хадгалан үлдэж улам боловсронгуй болгох, төрийн удирдлага, төрийн байгууллага, нийгмийн бусад институт хоорондын уялдааг оновчтой болгох болон төрөөс тавьж буй зорилгод хязгаарлагдмал нөөцөөр зохистой хүрэх явдлыг мэдлэг оюуны талаас нь хангах хэрэгцээ шаардлага бий болж үүнтэй зэрэгцэн шинжлэх ухаан ч уламжлалт заагийг давж өөр хоорондоо интеграцчилагдах хэрэгцээ үүссэн нь бодлого судлалын ухаан үүсэхэд нөлөөлсөн хэмээн үзэж болох юм.

Бодлогын ухаан нь улс төр, танин мэдэхүй эпистемологи, удирдахуйн ухаан гэх зэрэг нийгэм хүмүүнлэгийн томоохон салбар ухаануудын зааг дээр үүсэж хөгжсөн бөгөөд нийгэм, хүмүүнлэгийн хэд хэдэн салбарыг интеграцчлах оролдлого 1951 онд анхлан Лассуэл, Д.Лернертэй хамтран бичсэн “Бодлогын ухаан: хамрах хүрээ, аргын хөгжил”, 1947 онд Х.Саймон “Захиргааны зан үйлдэл: захиргааны байгууллагад шийдвэр гаргах үйл явцыг судлах нь” гэх зэрэг бүтээлүүдэд тусгалаа олж эхэлсэн байна.

Үүний зэрэгцээ XX зууны дундуур АНУ-д “Төрийн захиргаа” хичээлийг их, дээд сургуулиудад идэвхитэй зааж эхэлсэн нь төрийн бодлогыг судлах явдлыг өргөжүүлэх, улмаар энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх эхлэл болсон байна.

Улс төр судлаач, эдийн засагч, сэтгэл судлаач, эрх зүйч зэрэг олон эрдэмтэд татагдан орж бодлого судлалын онолын тулгуур ойлголт, үзэл баримтлал, хандлагыг тодорхойлох ажил идэвхитэй өрнөн, их сургуулиудад төрийн бодлогын хичээлийг туршилтын журмаар зааж эхлэн сурах бичиг, сэтгүүлүүд анхлан хэвлэгдэн гарч байжээ. Үүний дараагаас 1980-аад оны дунд үеэс бодлогын шинжлэх ухаан салбарлан “төрийн бодлого”, “бодлогын шинжилгээ” зэрэг чиглэлүүд хүлээн зөвшөөрөгдөж, төрийн захиргааны сургуулиудын сургалтын хөтөлбөрт орж эхэлсэн байна. Ийнхүү төрийн бодлогын чиглэлээр судалгаа явуулдаг мэргэжлийн байгууллага, холбоод байгуулагдан бодлогын судалгаа, бодлогын шинжилгээний чиглэлээр олон улсын “Journal of Policy analysis”, “Policy studies review” зэрэг эрдэм шинжилгээний сэтгүүлүүд хэвлэгдэн гарах болсноор бодлогын ухааны үр хөврөл өнөөгийн нийгэм, улс төрийн шинжлэх ухааны салбарт хэдийнээ өөрийн байр сууриа олжээ.

Бодлого судлалын хөгжилд эдийн засгийн судалгаа, философи, сэтгэл судлал, мэдээллийн шинжлэх ухаан чухал хувь нэмэр оруулсан бөгөөд энэ утгаараа бодлогын судалгаа нь практикт эдийн засаг, улс төр, түүх, социологи болон хэл шинжлэл, сэтгэл зүйн шинжлэх ухааны арга хэрэгслийг ашигладгаараа ихээхэн онцлог. Үүний зэрэгцээ Лассуэлл бодлогын ухааны хэд

хэдэн онцлог шинжийг нэрлэсэн байна. Нэгдүгээрт, бодлогын үйл явцын бүхий л үе шатыг судална. Хоёрдугаарт, бодлогын ухаан нэг талаар бодлогын үйл явцын тухай шинжлэх ухааны мэдлэгийг бий болгох, өөрөөр хэлбэл, түүний дотоод механизмыг тодруулах, нөгөөтэйгүүр амьдралд бодитойгоор оршин буй асуудлыг шийдвэрлэх тухай мэдлэгийг хуримтлуульж, холбогдох зөвлөмж боловсруулах гэсэн давхар зорилтыг шийдвэрлэнэ. Гуравдугаарт, бодлогын асуудлыг сегментчлэн хуваан тус тусд нь бус, харин цогц байдлаар шинжилнэ. Дөрөвдүгээрт, салбар дундын шинжтэй, арга зүйн олон хандлагад тулгуурлана. Үүнээс үзэхэд бодлогын ухаан бол академик болон хэрэглээний шинжтэй бөгөөд бодлогын уг чанарыг танин мэдэх хийгээд бодлогыг сайжруулахад чиглэсэн судалгааны аль алиныг өөртөө алгуулна.

Бодлого судлалын гол судлагдахуун нь төрийн бодлого хийгээд түүнийг хэрэгжүүлэх үйл явц юм. Шинжлэх ухааны үүднээс төрийн бодлого гэдгийг эрдэмтэд олон янзаар тодорхойлсон байдаг. Томас Дай “төрийн бодлого гэдэг нь төрөөс хийхээр эсвэл эс хийхээр сонгосон зүйл гэж тодорхойлохдоо нэгдүгээрт, төрийн бодлогын субъект бол засаг төр”[4] гэдгийг онцолсон байна. Хоёрдугаарт, төрөөс тодорхой үйл ажиллагаа явуулах, эсвэл ямар нэг зүйлийг шинээр хийхгүй байх буюу одоогийн байдлыг хадгалах гэсэн үндсэн сонголтыг төрийн бодлого агуулж болохыг хэлжээ.

Уилльям Женкинс “Төрийн бодлого бол тодорхой нөхцөлд зорилго, түүнд хүрэх арга замыг сонгохын тулд улс төрд оролцогч буюу хэсэг оролцогчоос гаргасан харилцан холбоо бүхий цогц шийдвэр юм”^[5] гээд эдгээр шийдвэр нь оролцогч талуудын эрх мэдлийн хүрээнд байх ёстой гэсэн байна. Нэг удаагийн шийдвэр гаргаснаар асуудлыг шийдвэрлэх нь ховор. Иймээс Женкинс төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь зорилгод чиглэсэн үйл ажиллагаа юм гэсэн санаа гаргасан. Мөн төр гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх чадвартай байх тухай давхар хэлсэн байна.

Жеимс Андерсон “төрийн бодлого гэдэг нь асуудлыг шийдвэрлэхийн тулд нэг буюу хэд хэдэн оролцогчоос явуулж буй зорилгот үйл ажиллагааны чиглэл”[6] гэж тодорхойлсон байна.

Төрийн бодлогын талаарх эдгээр тодорхойлолтууд нь өөр хоорондоо ялгаатай ч дараах санаануудаас **“Төрийн бодлого гэдэг нь төрийн байгууллага, албан тушаалтнуудын хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд нийгэмд тулгамдсан асуудлыг хэсэгчилсэн болон цогц байдлаар шийдвэрлэх үйл ажиллагааны чиглэл”** хэмээн тодорхойлж болно. Ийнхүү төр өнөөгийн нарийн төвөгтэй, ээдрээтэй холбоо харилцаа бүхий орчин цагт ард түмэн, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа, үр ашигтай бодлого боловсруулахад бодлого судлалын ухаан голлох байр суурь эзэлнэ.

Төрийн бодлогыг Т.Лови зохицуулалтын, хуваарилалтын, дахин хуваарилалтын гэж ангилсан байна. Зохицуулах бодлого нь эдийн засгийн зохицуулалт, хэрэглээний зах зээлийг хамгаалах зэрэг үйл ажиллагааг төрийн байгууллагаас зохицуулах үйлдлийг агуулна. Хуваарилах бодлого нь нийгмийн хөтөлбөр, боловсрол, шинжлэх ухаан гэх мэт материаллаг баялаг, ашиг тусыг хүн амын янз бүрийн бүлгийн дунд төрийн байгууллагын зүгээс хуваарилах үйл ажиллагаатай холбоотой. Дахин хуваарилах бодлого нь татвар, тариф, шилжүүлгийн хэлбэрээр тодорхой нөөцийг хүн амын нэг бүлгээс нөгөө бүлэгт

шилжүүлэхийг илэрхийлнэ.

Мөн нийгмийн тодорхой хүрээнд өөр бусад шалгуураар төрөөс шийдвэрлэх шаардлагатай асуудлын шинж чанар, агуулгаас хамааруулан төрийн бодлогыг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилах боломжтой. Жишээ нь эрүүл мэндийн, боловсролын, нийгмийн халамжийн, хүн амын, ажил эрхлэлт гэх зэргээр ангилах бөгөөд эдгээр ангилал нь өөр өөр шинжлэх ухааны салбарт харъяалагдана. Энэ утгаараа бодлого судлалын ухаанд бусад **шинжлэх** ухааны эрдэмтдийн мэдлэг, чадварыг шаардаж дан ганц **нийгэм, улс төрийн** шинжлэх ухаан бус өөр бусад шинжлэх ухааны салбараас ч хөрвөн судалгаа шинжилгээ хийхэд бүрэн нээлттэй байдгаараа ихээхэн онцлог юм.

Дээр дурьдсанчлан бодлогын ухааныг нэгд. Төрийн бодлого, хоёрт. Бодлогын шинжилгээ хэмээх хоёр салбарын хүрээнд авч үзэж болох тухай Ёонг Яан, Лиза Квин нарын “Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь” бүтээлээс харж болно[7]. Төр, захиргаа нь аливаа судалгааг гардан гүйцэтгэдэг практик салбар болохын хувьд үүргээ гүйцэтгэхэд ашиглах хэрэгслүүдтэй байх учиртай. Тийм хэрэгслүүдийн нэг нь бодлогын шинжилгээ юм. Шинжилгээ гэдэг нь ямар нэг зүйлийг сайн ойлгохын тулд түүнийг үндсэн бүрдэл хэсгүүдээр нь салгаж үзэх гэсэн үг. Энэ утгаараа бодлогын шинжилгээ нь төрийн бодлогын үндсэн хэсгүүдийг задлан ялгаж судлахыг хэлж байгаа юм.

Улс төрийн шинжлэх ухаанд бодлогын шинжилгээг тайлбарлах хэд хэдэн хандлагууд байдаг ч мэдлэгийн шинж чанраар нь онолын бодлогын шинжилгээ (political analysis), хавсрага бодлогын шинжилгээ (public policy analysis) хэмээн ангилан авч үзэх нь нийтлэг хандлага ажээ. Бодлогын шинжилгээний онолын болон хавсрага судалгаа нь өөр хоорондоо судалгааны зорилго, судалгааны объект, субъектийнхээ хувьд ялгагдна[8].

Хавсрага судалгааны үндсэн зорилго нь улс төрийн оролцогчдын өмнө тулгамдаж буй төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгддэг ба энэ нь тодорхой цаг хугацааны болон орон зайн хүрээнд хэрэгждэг. Өөрөөр хэлбэл, түүний шийдвэрлэх асуудал нь нэн тулгамдсан байдгаараа онцлогтой. Хавсрага судалгааны объект нь аль болох богино хугацаанд шийдвэрлэгдэх ёстой тухайн үеийн улс төрийн практик тулгамдсан асуудлууд байдаг.

Харин бодлогын онолын судалгаа нь улс төрийн үзэгдэл юмсын мөн чанар, хэрэгжих механизмыг илрүүлэх зэрэг улс төрийн суурь, тулгуур асуудлыг тайлбарлах зорилготой ба уг судалгааны объект нь бүхэлдээ өнгөрсөн болон одоо үед болсон улс төрийн үйл явц болно.

Онолын судалгааны субъект нь юуны өмнө улс төр судлаач эрдэмтэд төвлөрсөн эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны байгууллага, их дээд сургууль байдаг бол хавсрага судалгааг шинжилгээний бие даасан, төрийн бус судалгааны байгууллагууд эсхүл төрийн бүтцэд хамаарах судалгааны төвүүд байна.

А.Вилдавски “Бодлогын шинжилгээ нь тухайн цаг үеийн улс төрийн үйл явцад оролцогчдын өмнө тулгамдаж буй бодлогын асуудлыг шийдвэрлэх арга хэрэгсэл мөн” гэж тодорхойлсон бол Д.Веймер, А.Байнин нар бодлогын шинжилгээг “нийгмийн үнэт зүйлсийг илэрхийлсэн улс төрийн шийдвэр гаргах талаарх захиалгачид хандсан зөвлөмж” гэж үзжээ. Түүнчлэн Оросын улс төр судлаач К.В.Симонов бодлогын шинжилгээг “улс төрийн тодорхой нөхцөл

байдал, үйл явдал, тэдгээрийн цаашдын явцыг урьдчилан судалж, улс төрийн оновчтой шийдвэр гаргах нөхцөлийг тодорхойлох явдал” гэж тодорхойлсон байна. Харин Мак Реи, Уилд нар “**бодлогын шинжилгээ гэдэг бол олон хувилбаруудын дотроос хамгийн шилдэгийг нь сонгохын тулд учир шалтгааныг гарган нотлох явдал**”[9] гэжээ. Энэ ч утгаараа бодлогын шинжилгээний үндсэн зорилго бол бодлогын зөв шийдвэрт хүрэх ажлыг хөнгөвчлөхөд оршино. Тиймээс бодлогын шинжилгээ нь тулгамдсан асуудлууд, хууль болон хуулийн саналууд, улс төрийн удирдлагын байр суурь, байгууллагын хөтөлбөр, хувийн хэвшлийн байгууллагууд, тэдгээрийн бодлого болон шийдвэр гаргахад хэрэгтэй бусад олон зүйлийг судлана.

Монгол дахь бодлогын судалгааны үндэс: ХХ зууны хоёр дугаар хагсаас нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаануудын уулзварт бие даасан шинжлэх ухаан болж хөгжсөн “Бодлого судлалын ухаан” нь дэлхийн нийгэм, эдийн засгийн хурдацтай өөрчлөлт, хөгжилтэй нэгэн хэмнэлээр хөгжиж, боловсрогдож байна. Өөрөөр хэлбэл нийгмийн шинжлэх ухааны салбарт хамгийн залуу, хамгийн боловсронгуй шинжлэх ухаан болж байгаа хэрэг юм.

Монгол Улсын хувьд бодлогын судалгаа нь нийгэм, улс төрийн шинжлэх ухааны хүрээнд төрийн бодлого, үйл ажиллагаанд заавар, зөвлөмж болох үндсэн чиглэлээр үүссэн.

ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн, Удирдлагын хөгжлийн институт, Төр, нийгмийн судалгааны академи, Төрийн бодлого, асуудал судлах төв зэрэг байгууллагууд нь тухайн нийгэм, цаг үеийн чухал асуудлуудад онол практикийн санал, зөвлөмж өгөх зорилготой судалгаа шинжилгээнүүдийг хийж байсан. Хожим нь шинэчлэгдэн зохион байгуулагдаж зарим судалгааны институт, төв нь Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт болж, 1999 онд Удирдлагын академи болон өөрчлөгдсөн байна. Харин Философи, социологи, эрхийн хүрээлэн нь 1972 онд байгуулагдсан цагаасаа эхлэн тухайн нийгмийн тулгамдсан асуудлуудад онол, практикийн санал зөвлөмж, боловсруулж удирдах дээд байгууллага болон бусад шийдвэрлэх газруудад хүргүүлж байжээ. Үүний зэрэгцээ бие даасан болон хамтарсан олон суурь судалгаануудын хүрээнд тухайн нийгэм, улс төрийн тулгамдсан асуудлуудыг онол, аргагүйн эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулах, судалгааны тайлан боловсруулах, нэг сэдэвт хамтын бүтээл гаргах зэргээр судлан боловсруулж, аливаа асуудлыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр оруулдаг байжээ. Ийнхүү үйл ажиллагаагаа явуулсаар 2015 онд Засгийн газрын тушаалаар Философийн хүрээлэн болж шинэчлэгдэн өнөөг хүртэл бодлого судлал, улс төр, социологи, философи, шашин судлал, ёс зүйн чиглэлээр ажиллаж байна.

Удирдлагын академийн Төрийн удирдлагын тэнхимийн багш Я.Бямбасүрэн, П.Доржсүрэн нарын бичсэн “Төрийн бодлого” ном нь төрийн бодлого, бодлогын шинжилгээг сонирхон судлах оюутан, судлаачдад зориулсан анхны гарын авлага байсан юм. Үүнээс хойш бодлого судлал, бодлогын шинжилгээг хөгжүүлэн бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсан хэд хэдэн бүтээлүүд хэвлэгдэн гарсан. Тухайлбал доктор, профессор А.Цанжидын англи хэлнээс орчуулсан Жои Юл Ли, Чад Андерсон нарын “Бодлогын шинжилгээ”, доктор Б.Даш-Ёндонгийн “Монголын хөгжлийн философи”, ШУА-ийн

Философийн хүрээлэнгээс гаргасан “Монголын нийгмийн өөрчлөлт” гэх зэрэг бүтээлүүдийг дурдаж болно. Мөн шинэ залуу судлаачдад гарын авлага, мэдээлэл болохуйц Н.Наранчимэг “Нийгмийн бодлого”, Я.Бумжаргал “Нийгмийн бодлогын зарим асуудлууд” зэрэг бүтээлүүд гарсан байна.

Монгол Улсын хэмжээнд төрийн болон төрийн бус бодлогын судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачид цаг үеийн хэрэгцээ шаардлагыг даган эрчимтэй нэмэгдсэн.

Төрийн мэдлийн хэмжээнд УИХ-ын Тамгын газрын дэргэд төрөөс гаргах бодлого шийдвэрийн хүрээнд судалгаа шинжилгээ хийх, үнэлгээ, дүгнэлт гаргах үйл ажиллагааны чиглэл бүхий “Бодлогын шинжилгээний төв” ажиллаж 2008 оноос тус байгууллагаас гаргасан “Бодлогын шинжилгээ” цуврал эрдэм шинжилгээний товхимол нь монголын бодлогын судалгааны салбараас гарч буй томоохон бүтээгдэхүүн байсан юм. Мөн төрийн үйлчилгээний салбар нэгжүүдэд чиглэгдсэн төрийн мэдлийн бодлогын судалгааны байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Жишээ нь Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт гэх зэрэг байгууллагууд байна.

Монгол улсад сургалт, судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ, нөлөөллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг маш олон судалгааны төрийн бус байгууллагууд байдаг. Тэдгээр нь цаг үеийн шинжтэй хувь хүн, албан байгууллага, нам, төрийн, хувийн хэвшлийн олон талын захиалагчдын хүсэлтээр мөн өөрсдийн судалгааны чиглэлээр олон төрлийн судалгаа шинжилгээ хийдэг ч тэр бүгдийг Бодлогын судалгааны байгууллага, мөн гаргасан ном, товхимол, зөвлөмж болгоныг бодлогын судалгааны бүтээгдэхүүн гэж хэлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл төрийн бодлого, шийдвэр нь ард түмэн хийгээд нийгмийн эрх ашгийг багтаан авч үздэг, харин хувь хүн, албан байгууллагын хэмжээнд бодлого, шийдвэр гаргахад чиглэгдсэн судалгаа нь хэдий бодлогын судалгаа мөн боловч тухайн чиглэл салбарын асуудал л тусгагдсан байдаг. Тиймээс үүнийг төрийн бодлогын судалгаа, шинжилгээтэй хольж ойлгож боломгүй. Гэхдээ монгол улсын хэмжээнд Төрийн бодлого, шийдвэрт зөвлөмж, чиглэл үзүүлж чадахуйц мэдлэг, чадвартай, арвин туршлага хуримтлуулсан, хүлээн зөвшөөрөгдөхүйц эрдэмтдээр удирдуулсан, чадварлаг боловсон хүчнээр бүрэн хангагдсан хэд хэдэн Төрийн бус Бодлогын судалгааны байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал Нээлттэй Нийгэм Форум судалгаа, шинжилгээний салбар үүсч хөгжхөд тодорхой үүрэг гүйцэтгэж байна. Бодлогын судалгааны гарын авлага, бодлого судлаачдын тэтгэлэгт хөтөлбөр болон бусад олон чиглэлийн сургалт хэлэлцүүлэг арга хэмжээ зохион байгуулдаг. Мөн IRIM, MMCG, Максима консалтинг зэрэг судалгааны байгууллагуудыг дурдаж болох юм.

IV. Хэлэлцүүлэг

Монголын бодлого судлалын салбарт гарсан нэг том алхам бол улс орны нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг сонгуульд ялсан намын дөрвөн жилийн хугацаатай үйл ажиллагааны хөтөлбөрүүд хангаж чадахгүй болох нь илэрхий болсонтой уялдуулан “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг Монгол Улсын Засгийн Газраас

боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-д өргөн барьж 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр 12 дугаар тогтоолоор баталсан явдал юм. Энэхүү баримт бичиг нь тухайн үеийн Монголын тэргүүлэх 40 орчим эрдэмтэн багш нарийн оюуны болон практик үйл ажиллагааны үр дүн, бүтээгдэхүүн байжээ. 2014 онд Монгол Улсын Засгийн газрын захиалгаар ШУА-ийн дэргэдэх Үндэсний хөгжлийн хүрээлэн (одоо Стратегийн судалгааны хүрээлэнтэй нэгдсэн) уг урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэнд судалгаа хийж “Мянганы хөгжлийн зорилтот суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн үнэлгээ” гэх тайлан бүтээл гаргасан байна. Тайланд “цаашид Монгол Улс 2025 он хүртэл Мянганы хөгжлийн зорилтот суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын чиг баримжаагаар явах боломжгүй” хэмээн үзэж, тус судалгаагаа үргэлжлүүлэн “Хөгжлийн урт хугацааны бодлогын харицуулсан шинжилгээ” хэмээх судалгааны бүтээл гаргажээ. Ийнхүү 2 судалгааны үр дүн, өмнөх он жилүүдийн туршлагадаа тулгуурлан мөн онд “монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого 2015-2040” төслөө боловсруулан 2014 оны 4 сарын 15-нд УИХ-д танилцуулсан юм. Энэхүү судалгаануудын үр дүнг үндэслэн УИХ-аас “Монгол улсын хөгжлийн урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх” үүрэг бүхий ажлын хэсгийг нам, эвслийн бүлгүүдийн дарга нараар ахлуулан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Гэтэл 2015 оны 11 сард Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль батлагдсан бөгөөд тус хуулинд “урт хугацааны хөгжлийн бодлого хамгийн уртдаа 20 жилээр батлагдана” гэж зааснаар 2015-2040 оныг хүртэл хөгжлийн бодлого боловсруулах боломжгүй болж дахин ажлын хэсэг байгуулагдан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” төслийг боловсруулан 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлан хэрэгжүүлж байсан.

Энэ нь монголын урт хугацааны хөгжлийн бодлогын төлөвлөлт, судалгааны хамгийн бодит үр дүн байсан төдийгүй бодлого судлалын ухааны үүсэл хөгжлийн үр нөлөө байлаа.

Өнөөдөр Монгол Улсад 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” монгол улсын хууль батлагдан хэрэгжихийн зэрэгцээ, тус оны 5 дугаар сарын 13-ны өдөр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого хөтөлбөр батлагдан хэрэгжиж байна. Ийнхүү монголын төрийн үйл ажиллагаа, богино болон урт хугацааны бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг дүгнэн шинжлэх бодлогын шинжилгээ, бодлого судлалын ухааны онол, практикийн өргөн мэдлэг шаардаж эхэлсний зэрэгцээ энэ чиглэлийн шинжлэх ухааны чадавхи, хүний нөөцийг нэмэгдүүлэх хэрэгцээ бий болж байна.

Монгол Улсад “бодлого судлал” тодорхой төвшинд хөгжиж байгаа ч эдийн засаг нь хөл дээрээ тогтсон, судалгааны арвин туршлага, мэдээллийн баазтай, улс төрчид нь судалгаанд тулгуурлан бодлого боловсруулж дадсан, үндэсний судалгааны чадавхитай дэлхийн зарим улс орнуудтай харицуулшгүй юм.

Эдийн засгийн өөрчлөлт, мэдээллийн даяаршил, үйлдвэрлэл, үйлчилгээ, техник, технологи гэх мэт нийгмийн хөгжлийг тодорхойлох бүхий л хүчин зүйлс хоорондоо аалзны тор мэт харилцаа холбоон дээр тогтох болсон энэ цаг үед бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлтээрээ хамгийн хүчтэй улс орон л байгаа бүх боломж бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж цаашлаад олон улсад

байр сууриа тодорхойлж чадна. Үүний урьдач нөхцөл нь яах аргагүй цаг үе, нийгмийн өөрчлөлтийг урьдчилан тооцоолох чадвартай, үнэн, зөв, бодитой мэдээллийн эх сурвалж бүхий Бодлогын судалгааны институци юм. Ийм институцийг төгс утгаар нь биш гэхэд хамгийн наад захын хэрэглээ болгох, хэрэгжүүлэх нь бидний өнөөгийн нэн чухал зорилт байх ёстой.

Бодлого судлалын ухааныг цаашид гүнзгийрүүлэн судлах нь улс төрийн бодлого, шийдвэрийг үр ашигтай хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Тиймээс бодлого судлалын ухааны хөгжлийн түвшинг бодитой үнэлэн, суурь онол, үзэл баримтлалын судалгааг гүнзгийрүүлэх шаардлагатай.

Ашигласан материал.

1. Цэвэл Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 87 дахь тал
2. Cambridge dictionary. <https://dictionary.cambridge.org/us/dictionary/english/policy>
3. Бямбасүрэн Б., Доржсүрэн П. (2006). Төрийн бодлого. Уб., 4 дэх тал
4. Мөн тэнд., 11 дэх тал
5. Мөн тэнд., 12 дахь тал
6. Мөн тэнд., 12 дахь тал
7. Еойн Янг, Лиза Квин. (2002). Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь, Уб., 9 дэх тал
8. УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв. (2007). Бодлогын шинжилгээ-II. Эрдэм шинжилгээний бичиг. Уб., 10 дахь тал
9. Юл Ли Ж., Андерсон Ч. (2010). Бодлогын шинжилгээ. Орч Цанжид А. Уб., 16 дахь тал

V. Талархал. Энэхүү тойм өгүүллийг маань хүлээн авч олон нийтийн хүртээл болгох боломж олгож байгаа Философийн хүрээлэн, мөн “Философи эрх зүйн судлал” эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцийн зөвлөл, уншилт хийж үнэлгээ, зөвлөмж өгсөн редакцийн гишүүнд гүнээ талархаж байна. Эрдэм судлалын ажилд суралцаж буй залуу эрдэм шинжилгээний ажилтан надад маш их урам хайрлалаа. Төгсгөлд нь эрдэм судлалын ажлын арга ухаанд үргэлж зааж, чиглүүлж явдаг Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, ЭШТА, доктор (Ph.D) О.Хатанболд, ЭШДЭА, докторант А.Хишигдаваа нартаа талархаж явдгаа энэ дашрамд илэрхийлье.